

“ХАН-УУЛ ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ” ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/44 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, Наадамчдын зам дагуу Яармагийн автобусны 2 дугаар буудал орчмын явган хүний гарцаас далан руу гардаг эвдрэлтэй шатыг засвараж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/140 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 19,20 дугаар хороо, 27 дугаар цэцэрлэгийн хойд уулзвараас “Монгол нэхмэл” ХХК-ийн хашаа хүртэлх 80м урт хатуу хучилттай асфальтан авто зам, тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/305 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодын гэр хорооллын гудамж талбайн 47,515м² зохист найрлагатай хайргаар засварлах ажлын хүрээнд нийт 22 гудамжийг засварлаж тус гудамж талбайд 88 ширхэг хурд сааруулагчийн тэмдэг тэмдэглэгээ суурилуулж ажилласан



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/314 дүгээр захирамжаар Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо Ханбогд хотхоны туслах замаас төв зам руу гардаг хуучин бетон шатыг шинэчилж ажилласан. Мөн тус хорооны төв замаас Вива сити орох хүртэлх замын дунд 45ш бетон эгнээ тусгаарлагч хийж авто замын түгжрэлийг бууруулсан. Хүннү молл хулдааны төвийн баруун урд хэсэгт явган хүний замыг шинээр хийж төв замын явган хүний хашлага хэвтүүлэх ажил хийж дууссан. Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн албатай хамтарч Хан-Уул дүүргийн 10, 12, 13 дугаар хороодын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал тээвэрлэлтэд хяналт тавих зорилгоор нийт 39 босоо тэмдэг тэмдэглэгээг авто замын хажууд суурилуулж ажилласан. Тус ажилд нийт 114,389,850₮ зарцуулсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/398 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны гэр хорооллын 10,297м² гудамж зам талбайг зохист найрлагат хайргаар засварлах ажлын хүрээнд:

- Буянт-Ухаа 23-2 гудамж
- Буянт-Ухаа 23-2 гудамж
- Буянт-Ухаа 20 гудамж
- Буянт-Ухаа 13 гудамж
- Буянт-Ухаа 15 гудамжуудыг засварлаж тус гудамж талбайд 20 ширхэг босоо

тэмдэг тэмдэглэгээ суурилуулж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/429 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Вива сити хотхоны авто замын үерийн усанд угаагдсан хэсгийг зохист найрлагатай хайргаар далан босгож бетон болон чулуугаар засварлаж ажилласан. Тус засварласан хэсгийн авто замын асфальт хэсгийг засварлаж байнгын ашиглалтад оруулсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/432 дугаар захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 1, 2, 10, 11, 18, 19, 20, 23, 24 дүгээр хороодын авто замын эвдэрсэн хэсгийн нүхийг зүсэж авч 2492.99м² талбайн нөхөөсний ажлыг бүрэн гүйцэтгэж ажилласан. Тус авто замын эвдэрсэн хэсгийн нөхөөсний ажлыг бүрэн хийж гүйцэтгэснээр явган зорчигчийн аюулгүй байдал, авто тээврийн осол, авто замын түгжрэлийг бууруулсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/433 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны гэр хорооллын үерийн усанд эвдэрч иргэд болон тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлах ажлын хүрээнд нийт 5 гудамжны 13,090м² зам талбайг засварлаж гудамж зам талбайд хурд сааруулагч болон 20ш босоо тэмдэг тэмдэглэгээ суурилуулж иргэдийг эрүүл, аюулгүй орчин нөхцлөөр хангаж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/461 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны борооны ус ихээр тогтдог, иргэд олон нийт зорчиход хүндрэлтэй гэр хорооллын нийт 5 гудамж зам талбайн 30,400м² зохист найрлагатай хайргаар засварлах ажил, тэмдэг тэмдэглэгээ болон хурд сааруулагчийг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/484 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 7 дугаар хорооны гэр хорооллын гудамж зам талбайн 1,890м² зохист найрлагатай хайргаар засварлах, үерийн усны суваг шуудууны засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэж үер усны болзошгүй эрсдэлийг бууруулж ажилласан.




Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/485 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны гудамж зам талбайн 1,050м² зохист найрлагатай хайргаар засварлах ажил, 22 дугаар хороо Номун виллаж хотхоны урд талд тохижилтын талбайн тэгшилэх ажил бүрэн хийгдэж дууссан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/499 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны ус ихээр тогтож иргэд болон авто тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй гэр хорооллын гудамж зам талбайн 11,445м2 зохист найрлагатай хайргаар засварлах ажлын хүрээнд нийт 5 гудамж зам талбайг засварлаж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/500 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны гэр хорооллын гудамж зам талбайн 20,850м2 зохист найрлагатай хайргаар засварлах ажлын хүрээнд нийт 5 гудамж зам талбайг засварлаж бүрэн дууссан.




Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн А/512 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын нийт 55 сургууль, нийт 121 цэцэрлэг орчмын авто замын сэргээн засварлах шаардлагатай хэвтээ тэмдэг тэмдэглэгээ 391,2м2, босоо тэмдэг 80ш суурилуулж ажилласан. Тус ажлыг хийж гүйцэтгэснээр авто тээврийн осол, авто замын хөдөлгөөнд хүүхэд, иргэд олон нийтийг аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/513 дугаар захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны гэр хорооллын нийт 5 гудамж зам талбайн 9,728м2 зохист найрлагатай хайргаар засварлаж тэмдэг тэмдэглэгээ болон хурд сааруулагчийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/536, А/537 дугаар захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 16, 25 дугаар хороодын гэр хорооллын гудамж зам талбайн 19,990м² зохист найрлагатай хайргаар засварлаж босоо тэмдэг тэмдэглэгээ болон хурд сааруулагчийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/567 дугаар захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны зам талбайн 1,350м² зохист найрлагатай хайргаар засварлаж бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/589 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны гэр хорооллын зам талбайн 9,898м² зохист найрлагатай хайргаар засварлаж бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/590 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны гэр хорооллын нийт 12 гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлахаар ажиллаж байна.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/591 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, 134 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн авто зогсоолын ажлыг шинээр хийх ажлын 90%-ийг гүйцэтгэсэн. Одоогоор ус шүүрүүлэх худаг болон хэвтээ, босоо тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 10 дүгээр сарын 04-ний өдрийн А/601 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо Вива сити орох зам, 11дүгээр хороо Рома таун хотхоны зүүн талын зам, Энхжин хотхоны баруун талын зам, 20 дугаар хорооны Органик захын авто замд эгнээ тусгаарлагч бариар болон 3,660м² зохист найрлагатай хайргаар засварлаж хийж гүйцэтгэж авто замын түгжрэл болон явган зорчигчийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ”


2.1.1 Олон нийтийн арга хэмжээний хүрээнд

Хан-уул дүүргийн 20 дугаар хороо, Цагаан хаалганаас Номин Юнайтед хүртэлх явган хүний зам талбай дээр үүссэн цас мөсийг нийт 15 ажилтан алба хаагч нарын хамт цэвэрлэж зорчих хэсгийг аюулгүй болгож ажилласан.



Хан-уул дүүргийн 3 дугаар хороо, Говийн авто зам, 14 дүгээр хорооны Кувейтийн аманд байрлах авто замын цас мөсийг нийт 10 ажилтан алба хаагч цэвэрлэж зорчих хэсгийг аюулгүй болгож ажилласан.

Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 09/75 тоот албан бичиг, удирдамжийн дагуу “Ердөө л 90 минут” аяны хүрээнд тус байгууллагын ойр орчмын 50 метр зайнд хамрагдах авто зам болон явган хүний замын цас мөсийг цэвэрлэсэн. Нийт 13 алба хаагч хамрагдаж 90 минутын хугацаанд хог хаягдлыг цэвэрлэж ажилласан.



Хан-Уул дүүгийн Засаг даргын 2023 оны А/56 дугаар захирамжаар баталсан “Хоггүй Хан-Уул 2023 аян” хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 11:00-12:00 цагийн хооронд нийт 60 минутын хугацаанд нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам талбайн цас мөс, эзэмшил газрын 50 метр хүртэлх талбайн хог хаягдлыг 12 ажилтан алба хаагчийн хамт 8 шуудай, 200 кг хог хаягдлыг цэвэрлэж ажилласан.



Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Ерөнхий боловсролын 114 дүгээр сургуулийн гадна байрлах эвдэрсэн авто замын төмөр хайс хашлагыг засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Хаврын их цэвэрлэгээ сарын аяны хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр 11:00-12:30 цагийн хооронд нийт 90 минутын турш нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа. Нийт байгууллагын 8 ажилтан хамрагдаж 10 шуудай нийт 250 кг хог хаягдлыг цэвэрлэж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар “Хоггүй Хан-Уул 2023” аяны хүрээнд хүүхдийн баярыг угтан “Хотоо угаая” бүх нийтийн их цэвэрлэгээг 2023 оны 5 дугаар сарын 12,26-ны өдрүүдэд 11:00-12:30 цагийн хооронд 2 удаа дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээнд нийт ажилтан алба хаагчид бүрэн хамрагдаж цэвэрлэгээ хийж ажилласан.



Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс Хүн бүр байгаль хамгаалагч, Шар өвс-Шатахуунтай адил шатна уриан доор ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ой хээрийн түймэр гарсан тохиолдолд цаг алдалгүй унтраах дадлага сургуулилт зохион байгуулсан тус арга хэмжээнд 5 алба хаагч хамрагдсан.



“Баялаг бүтээгч” иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, сурталчлах зорилготой төр, хувийн хэвшлийн хамтарсан “БҮТЭЭГЧ ХАН-УУЛЧУУД-2023” нээлттэй өдөрлөг “Мөсөн өргөө”-н гадна талбайд 06 дугаар сарын 04-нд амжилттай зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд механизм-5, тоног төхөөрөмж, байгууллагын нийт алба хаагчид үзэсгэлэн гаргаж нээлттэй өдөрлөгт төрийн үйлчилгээг үзүүлж үйл ажиллагааг нийтэд таниулан сурталчилж ажилласан.



“Нийслэлийн Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “Онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын дууриалган үзүүлэх дадлага сургуулалтад механизм-4, оператор-4, туслах ажилтан-3 алба хаагчдын хамруулж ажилласан.



Хан-Уул дүүргийн хэмжээнд шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэх бүх нийтийн ээлжит их цэвэрлэгээг 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 09.00 цагаас 12.00 цагийн хооронд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд байгууллагын ойр орчмын зам талбай, шарилж, хөл газрын ургамал, хог хаягдал, бүх нийтийн их цэвэрлэгээнд нийт ажилчин алба хаагчид бүрэн хамрагдаж 60м зам талбайг цэвэрлэж ажилласан.



Хичээлийн шинэ жилийг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээний хүрээнд 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 11:00-12:00 цагийн хооронд нийт 60 минутын турш нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам талбайн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа. Нийт байгууллагын 5 ажилтан хамрагдаж 5 шуудай хог хаягдлыг цэвэрлэж ажилласан.



ГУРАВДУГААР БҮЛЭГ “ГАМШИГ, ОНЦГОЙ НӨХЦӨЛД АЖИЛЛАХ”

3.1 Гамшиг онцгой нөхцөлд ажилласан тухай

Нийслэлийн нутаг дэвсгэрт үргэлжлэн орсон их борооны улмаас үүссэн үерийн аюул, гамшигын нөхцөл байдалтай холбогдуулан Хан-Уул дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 12:00 цагаас 07 дугаар сарын 08-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь өгсөн чиг үүргийн дагуу тухайн нөхцөлд үйл ажиллагаагаа хэвий зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Дунд гол орчмын хуримтлагдсан лаг шавар, хогийг зөөж тээвэрлэх, шуудайлсан элсээ далан руу шахаж тавих ажлыг экскаватор-1ш, ковш-1ш, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн.



Мөн 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах үерийн далан болон гүүрний байгууламж эрсдэлт нөхцөлд орсон тул үерийн даланг хүчитгэх, бэлэн байдалд байлгах ажилд экскаватор-1ш, ковш-1ш, нийт 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр аюулгүй байдлыг хангаж ажилласан



2023 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны Цагаан эргийн гүүр нь үерийн усны улмаас зорчих хэсэг хязгаарлагдсан байсан тул зорчих хэсгийн шороон замыг тэгшилж тус модон гүүрний хайлс, хашлага зэргийг сэлбэн засварлаж зорчих хэсгийг хэвийн нөхцөлд оруулж ажилласан.

